



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

**Байнгын хорооны дүрэмд нэмэлт  
оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсэгт заасныг үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос ТОГТООХ нь:


1. “Өргөдлийн байнгын хорооны дүрэм”-ийн долоодугаар зүйлд дараах агуулгатай 7.4, 7.5 дахь хэсгийг нэмсүгэй:

“7.4. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4.2-т заасан өргөдөл гаргагч, гэрч, шинжээчийг сонсох, холбогдох албан тушаалтнаас тайлбар авах үйл ажиллагааг бичгээр, эсхүл биечлэн ирүүлж нээлтэй болон хаалттай хүрээнд сонсох хэлбэрээр зохион байгуулна. Төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах асуудлыг хаалттай сонсоно.

7.5. Журмын 7.4-д заасан асуулт асуух, хариулт өгөх хугацааг тус бүр 5 минутаас илүүгүй байхаар дарааллыг зохицуулан хуралдаан даргалагч удирдаж явуулна. Шаардлагатай гэж үзвэл Байнгын хорооны ажлын алба болон мэргэжлийн судлаач, эрдэмтдийн санал дүгнэлт, мэдээллийг танилцуулж болно.”

2. Энэ тогтоолыг 2015 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



О.БААСАНХҮҮ